



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/77

Улаанбаатар хот

Хүнсээр хангах албаны бүтэц,
бүрэлдэхүүн батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 33 дугаар зүйлийн 33.3, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны "Заавар батлах тухай" 120 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх" журмын 2 дугаар хэсгийн 2.4.1, Нийслэлийн Засаг даргын 2017 оны "Зөвлөл, Нийслэлийн Онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журам, Шуурхай Ажлын хэсэг, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги байгуулах тухай" А/1008 дугаар захирамж, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах болон газар хөдлөлтийн үед голомтод ажиллаж байгаа шуурхай бүлэг, аврагчид, нэрвэгдэгсдийг хоол, хүнсээр хангах Хүнсээр хангах албаны /цаашид "штаб" гэх/ бүтцийг 1 дүгээр, бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.


2. Гамшгаас хамгаалах Хүнсээр хангах албаны төлөвлөгөө, ажил үүргийн хуваарийг батлан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Албаны дарга /Б.Эрдэнэчимэг/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2015 оны 05 дугаар сарын 12-ны А/58 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА *С.Самсүрэн* Ч.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны *Одундугаар* сарын *27* өдрийн
А/77 тушаалын *1 дүгээр* хавсралт



ГАМШГААС ХАМГААЛАХ БОЛОН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ҮЕД
“ХҮНСЭЭР ХАНГАХ АЛБА”-НЫ БҮТЭЦ



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 03 сарын 24 өдрийн
#179 тушаалын 03 сарын 24 хавсралт



ГАМШГААС ХАМГААЛАХ БОЛОН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ҮЕД
"ХҮНСЭЭР ХАНГАХ АЛБА"-НЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Хүнсээр хангах албаны дарга: - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
- Штабын дарга: - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан: - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, зах зээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан: - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Сургалт, мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдал хариуцсан ажилтан: - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн Худалдаа хариуцсан мэргэжилтэн
- Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан: - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн Ахуйн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Ар тал, хангалт хариуцсан ажилтан: - Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
- Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
- Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
- Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга

- Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
- Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
- Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
- Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
- Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга